



## ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 21 өдөр

Дугаар A/135

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.1 /а/, Сангийн сайдын 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг."БИЗНЕС ФОРУМ-ЭРДЭНЭТ" арга хэмжээний хүрээнд гадаадын зочид, төлөөлөгчдөд хүндэтгэл үзүүлэх хүлээн авалт, угтаж авах, үдэж өгөх ёслолын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр.Дээрх үйл ажиллагаанд шаардлагатай 4091000 /Дөрвөн сая ерэн нэгэн мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахыг Санхүү төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.



Д. БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны 3 дугаар сарын 21  
өдрийн 3 дугаар захирамжийн хавсралт

**"БИЗНЕС ФОРУМ -ЭРДЭНЭТ" ЧУУЛГА УУЛЗАЛТЫН  
ХҮНДЭТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ**

№	Зардлын нэр	Төсөв			
		Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ /төг/	Нийт дүн /төг/
1	Хөтлөгчийн ажлын хөлс	удаа	1	100,000	100,000
2	Нээлтийн урлагийн тоглолт	удаа	1	100,000	100,000
3	Хүлээн авалтын урлагийн тоглолт	удаа	1	100,000	100,000
4	Хүндэтгэлийн зоог, үйлчилгээ	хүн	250	14,160	3,540,000
5	хамгаалалтын цагдаагийн ажилтны буудлын өрөөний зардал	х/өдөр	2	55,000	110,000
7	Орон нутгийн брэнд бүтээгдэхүүний дээж	багц	8	13,500	108,000
8	Утгах үйлчилгээнд зогсох 3 хүүхдийн Үндэсний хувцас, урамшуулал	хүн	3	11,000	33,000
	Нийт дүн				4,091,000